GOBI

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20.25 он 12 сар 25 өдөр Дугаар 53 Улаанбаатар хот

***Зээлийн шугамын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай***

“Говь” ХК болон “Таван Богд Холдингс” ХХК, “Таван Богд Проперти” ХХК-ууд хамтран “Хас Банк” ХК-тай байгуулсан зээлийн шугамын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтуудыг тус тус үндэслэн “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

**1.** “Хас Банк” ХК-тай “Говь” ХК, "Таван Богд Холдингс" ХХК болон “Таван Богд Проперти” ХХК-уудын хооронд 2024 оны 03-р сарын 15-ны өдөр байгуулсан ЗГ5005760266 тоот Зээлийн шугамын гэрээнд дараах нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:

1.1. Зээлийн гэрээний хугацааг 36 /гучин зургаан/ сараар сунгах,

1.2. Хугацааны эцэст буюу 2029 оны 03-р сарын 15-ны өдөр эргэн төлөх,

1.3. Доорх хүү, шимтгэлийн өөрчлөлтийг 2026 оны 03-р сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөх,

1.3.1. Төгрөгийн шугамын зээлийн хүүг 16.8 /арван зургаа аравны найман/ хувь болгон нэмэгдүүлэх,

1.3.2. Ам.долларын шугамын зээлийн хүүг 8.8 /найм аравны найман/ хувь болгон бууруулах,

1.3.3. Үүрэг хүлээсний шимтгэл төгрөгийн зээлийн хувьд 2.0 /хоёр/ хувь, ам.долларын зээлийн хувьд 1.0 /нэг/ хувь болгон бууруулах,

1.4. “Таван Богд Проперти” ХХК нь “Таван Богд Холдингс” ХХК-тай бизнес нэгдэл хийсэнтэй холбоотой Зээлийн шугамын гэрээний хамтран зээлдэгчээс хасах,

**2.** Зээлийн шугамын гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар “Говь” ХК-ийн Хавсралт №1-д заасан хөрөнгүүдийг үргэлжлүүлэн барьцаалахыг зөвшөөрсүгэй.

**3.** Дээрх Зээлийн шугамын нэмэлт гэрээ, Барьцааны гэрээ, бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирал /Б.Оргил/-д олгосугай.

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998 д.д. 2076357

ТУЗ-ИЙН ДАРГА: ........................................ Ц.БААТАРСАЙХАН

ТУЗ-ИЙН ГИШҮҮД: ........................................ Б.АМАРСАЙХАН

........................................ Д.ГЭРЭЛМАА

........................................ А.ЖАРГАЛМАА

........................................ Б.ОРГИЛ

“Говь” ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17062, Монгол улс
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, И-мэйл: info@gobi.mn, Вэб сайт: www.gobi.mn

20 25 он 12 сар 25 өдөр | Дугаар 53 | Улаанбаатар хот

................................ Ц.ОРГИЛБОЛД

................................ Д.ХУЛАН

................................ Д.ХҮРЭЛБААТАР

................................ Б.ЦЭЭНЯМ